

МОНГОЛ УЛСАД ЦЭРГИЙН ДЭЭД ГЕНЕРАЛ ЦОЛ ОЛГОЖ ЭХЭЛСНИЙ 77 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛАВ

Монгол Улсынхаа төлөө зүтгэе!

СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.04.28 №41, 42 (41, 42)



МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм генералууд аа!
Та бүхэнд Монгол Улсад цэргийн дээд цол бий болсон өдөр Монгол генералын өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын төр засгаас генерал цолыг “Эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг батлан хамгаалах үйл хэрэгт онц гарамгай гавьяа байгуулсан цэргийн дээд дарга нарт олгоно” хэмээн журамлаж БНМАУ-ын Ардын сайд нарын зөвлөлийн 1944 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 52 дугаар тогтоолоор анх Ю.Цэдэнбал, Ж.Лхагвасүрэн нарын 11 хүнд генерал цол олгосноос хойш өнөөг хүртэл 186 хүн энэ эрхэм цолыг хүртжээ. Монгол Улс цэрэг армидаа генерал цолыг хэрэглэж эхэлсэн нь цаг хугацааны хувьд Халхын голын дайны шалгуурыг даван туулж ялалт байгуулсан, 1945 оны Чөлөөлөх дайны өмнөх эгзэгтэй үе байсан бөгөөд Монгол Улс дэлхий нийтийн хөгжлийн замаар алхаж, Монгол цэргийн дарга нар дэлхийн армиудын дарга нарын зэрэг зиндаанд хүрснийг илтгэн харуулсан явдал байсан юм.

Монгол Улсын генералуудаас Монгол Улсын баатар 6, Хөдөлмөрийн баатар 3 төрөн гарсан бөгөөд 1939 оны Халхын голын дайн, 1945 оны Чөлөөлөх дайнд 34 хүн оролцож, 15 хүн АИХ болон УИХ-ын гишүүн, сайд, орлогч сайд зэрэг төрийн өндөр алба хашиж, 11 хүн Монгол Улсын гавьяат хэмээх эрхэм цолыг хүртэж, 38 хүн эрдмийн цол зэрэг хамгаалж, 10 хүн олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцож НҮБ болон олон улсын бусад байгууллагад ажиллаж, олон хүн дипломат алба хашжээ. Энэ тоо баримт нь Монгол Улсын генералууд зөвхөн улс орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнол, аюулгүй байдлын төлөө төдийгүй Монгол улсынхаа хөгжлийн үйл хэрэгт манлайлан оролцож ирснийг гэрчилж байна.

Монгол Улсын генералууд Монгол Улсынхаа эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө, улс орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө оршин байгаа үедээ чадах бүхнээ хийж манлайлан зүтгэх болно.

Эрхэм генералууддаа Монгол Улсад генерал цол бий болсны 77 жилийн ой Монгол генералын өдрийн баярын мэндийг дахин дэвшүүлж та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Цэргийн сүлд хийморь мөнхөд бадарч байх болтугай!

МОНГОЛ ГЕНЕРАЛ
ТББ-ЫН ТЭРГҮҮН ДОКТОР,
ПРОФЕССОР, ХОШУУЧ ГЕНЕРАЛ
С.БААСАНХҮҮ

МЭНДЧИЛГЭЭ



Монгол цэргийн сүр хүч, сүлд хийморь болсон алтан мөрдэстнүүддээ “Монгол генералуудын өдөр”-ийн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Монгол Улсад генерал хэмээх эрхэм цолыг олгож, хэрэглэж эхэлсээр өдгөө 77 дахь жилдээ энэхүү өдрийг бид угтаж байна.

БНМАУ-ын Ардын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор анх генерал цол олгож эхэлсэн энэ өдрийг эх орныхоо халдашгүй дархан байдлын төлөө тангараг өргөн зүтгэсэн цэргийн дээд цолтнуудынхаа үйл хэрэг, эх орныхоо өмнө байгуулсан алдар гавьяаг мөнхжүүлэн, хүндэтгэл үзүүлэх, бахархан дуурайх үзлийг хойч үедээ төлөвшүүлэх, тэдний цэргийн хэргийн өргөн мэдлэг, цэрэг амьдралын баялаг туршлагаас суралцах явдлыг эрхэм

Монгол Улсынхаа тусгаар тогтнол, улс орныг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах үйл хэрэг, хөгжил дэвшилд ухамсарт амьдрал, хөдөлмөр зүтгэлээ зориулсан бэлтгэл, чөлөөнд буй генералууд, өдгөө Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын өндөр хариуцлагатай албанд амжилт дүүрэн зүтгэж буй эрхэм генералууд Та бүхэнд Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүний өмнөөс “Монгол генералын өдөр”-ийн баярын мэндийг дэвшүүлье!

Генерал хэмээх эрхэм хүндтэй цэргийн дээд цолыг БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн 1944 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 52 дугаар тогтоолоор Ю.Цэдэнбал, Ж.Лхагвасүрэн, С.Балдан, Д.Дамдинхүү, С.Равдан, Б.Дорж, Г.Дагдан, Б.Шагдаржав, Г.Рэндоо, М.Зайсанов, Р.Осор нарын 11 офицерт олгосон түүхтэй.

Энэхүү түүхэн өдрийг 2004 оноос хойш “Монгол генералын өдөр” болгон тэмдэглэж ирснээр төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд жил бүр ээлжлэн цэргийн дээд цолтнуудаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлдэг бахархалт уламжлал тогтсон бөгөөд алтан мөрдэст генералуудаараа бахархах, тэдний гавьяа зүтгэл, дайчин уламжлалыг нь хойч үеийнхэнд өвлүүлэх, монгол бахархлыг түгээн дэлгэрүүлэх өндөр ач холбогдолтой юм.

Манай орны түүхийн бүхий л үе шатанд эх орныхоо тусгаар тогтнол, халдашгүй дархан байдал, хүн зонхилоо амар амгалан, аюулгүй байдлыг батлан хамгаалах, бататган бэхжүүлэх, хөгжлийг түргэтгэж, шинэчлэлийг эрчимжүүлэх үйл хэрэгт манлайлан зүтгэсэн эрхэм генералууд Та бүхний бүтээлч хөдөлмөр, бахдам амжилтыг баярын энэ өдөр бахархан тэмдэглэж байна.

Өнөөдөр та бидний залгамж халаа болсон Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын нийт албан хаагчид нь халдварт цар тахлын нэн хүнд бөгөөд тун харуцлагатай нөхцөлд эх орноо батлан хамгаалах ариун үүргээ нэр төртэй биелүүлж, даян дэлхийн энх амгалангийн үйлсэд мэргэжил, ур чадвараараа гайхагдан, улс орныхоо бүтээн байгуулалтад манлайлан оролцож, аливаа осол аюул, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, хор уршгийг нь арилгах үйл хэрэгт идэвх санаачилгатайгаар хөдөлмөрлөж байгаад чин сэтгэлийн талархал илэрхийлэе.

Монгол эх орон, төр, ард түмнийхээ өмнө өргөсөн тангаргаа үнэнчээр биелүүлэн, мэргэжил, дадлага, ур чадвар, авьяас билгээрээ мөрдэс нэгт нөхдөө ямагт манлайлан дагуулагч байж, хариуцсан салбар, байгууллага, хамт оныхоо өмнө дэвшүүлсэн зорилго, зорилтуудыг амжилттай шийдвэрлэхэд голлох үүргийг гүйцэтгэсээр ирсэн эрхэм генералууд Та бүхнийхээ ажил үйлсэд арвин их амжилт, амьдралд тань аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг бэлгэдэн ерөөе!

Монгол цэргийн сүр хүч, сүлд хийморь үеийн үед мандан бадрах болтугай!

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД, БРИГАДЫН ГЕНЕРАЛ Г.САЙХАНБАЯР

болгон тэмдэглэж ирсэн билээ.

“Байлдагчийн халаасанд генералын мөрдэс бий” гэж манай цэргийнхэн ярьдаг. Үнэхээр ч нэгэн үзүүрт сэтгэлээр төр, улсынхаа төлөө зүтгэсэн мянга мянган цэрэг эрсийн дундаас уйгагүй хөдөлмөр, хичээл зүтгэл, өөртөө тавьсан өндөр зарчимч шаардлага, үйл хэргээрээ шалгарсан шилдэг хөвгүүдээ Монгол төр үнэлж, генералын алтан мөрдсийг соёрхон олгодог билээ.

Дэлхийн түүхэнд нэр, алдраа мөнхөлсөн хурц ухаантай, эрэлхэг зоригтой, баатарлаг цэргийн аугаа жанжид Монголын түүхнээ цөөнгүй тодрон гарсан юм. Цэргийн түүх, цэргийн урлаг судлаач дэлхийн шилдэг эрдэмтэд өнөөдөр ч Монгол жанждын суут ухаан, цэрэг засах, захирах, байлдах урлагийг шимтэн судалж, зохиол бүтээлдээ тусгаж, орчин үеийн шинжлэх ухаан, технологийн ололт дэвшилтэй хослуулан, стратеги судлалыг гүнзгий хөгжүүлэн улам боловсронгуй болгосоор байгаа нь бидний өвөг дээдсийнхээ суу алдраар бахархах үзлийг хөгжүүлж, “Би Монгол хүн” гэх омогшлыг үргэлж бадрааж байдаг.

Өвөг дээдэс, ахмад үеийнхээ үйл хэргийг нэр төртэй залгамжилж өдгөө ч манай эрхэм генералууд өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудад албаа нэр төртэй хааж, Монгол төрийн батлан хамгаалах бодлого, зорилт, үйл ажиллагааны түшиг тулгуур, хөдөлгөгч хүч нь байсаар байна.

Эх орон, төр, ард түмнийхээ итгэл хүндлэлийг хүлээж, улс Монголынхоо халдашгүй дархан байдлыг батлан хамгаалах үйл хэргийн манлай болсон эр цэргийн хийморь, эрхэм генералууд Та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Та бүхнийг Монгол цэргийн догшин Их Хар сүлд үргэлжид ивээж байх болтугай.

ЦЭРЭГ АРМИ БАЙГАА ЦАГТ ТЭДНИЙГ УДИРДАХ ДЭЭД ДАРГА, ГЕНЕРАЛУУД БАЙХ ЁСТОЙ

Монгол цэргийн музейн эрдэм шинжилгээний ажилтан-түүхч Ж.ОДОНТУЯА

ЦЭРГИЙН ЦОЛНЫ ҮҮСЭЛ

Монголчуудын хувьд өнө эртнээс цэргийг үүсгэн байгуулж, төр улсаа сахин хамгаалж ирсэн арвин баялаг уламжлалтай бөгөөд тэрхүү цэргийг удирдах дарга, жанждаа баатар, хөлөг баатар, мянгат, түмтийн ноён гэх зэргээр нэрлэж байсан нь нэг талаараа албан тушаал боловч нөгөө талаараа цэргийн цолыг давхар илэрхийлж байжээ. 1921 онд ялсан Үндэсний ардчилсан хувьсгалын үр дүнд шинэ засаг тогтож, Монгол Улс хөгжил дэвшлийнхээ замд орсон билээ. Энэ үеийн нэн чухал зүйлийн нэг нь Монгол Улсын тусгаар тогтнол, бие даасан байдлыг бэхжүүлж, батлан хамгаалах чадвартай Зэвсэгт хүчнийг байгуулсан явдал юм.

Монгол Ардын Хувьсгалт цэргийг байгуулж хөгжүүлсэн олон талт үйл ажиллагааны дотор захирах командлах бүх шатны боловсон хүчнийг бэлтгэж, тэдэнд зэрэг дэв тогтоон, цэргийн алдар цол олгож ирсэн нь өнөөгийн цэргийн цолны үүсэл байсан гэхэд буруудахгүй. Орчин цагийн Зэвсэгт

1944 оноос эхлэн генерал хэмээх цолыг хэрэглэж иржээ. БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1944 оны 4 дүгээр сарын 28-ны 22 дугаар хурлаар "МАХЦ-ийн нийт дарга нарыг офицер хэмээн нэрлэх ба нийт албан хаагчдын алдар цолыг шинэчлэх тухай" тогтоол гарсан. Тогтоолоор МАХЦ-ийн бие бүрэлдэхүүнийг байлдагч, бага дарга, офицер, генерал хэмээн нэрлэх болж, ялгах тэмдгийг шинэчлэн баталж, бригад, дивиз, корпусын командлагчийг генерал цолоор сольж, 11 дээд даргад анхны генерал цол олгосон түүхтэй.

1936 оны 2 дугаар сарын 21-ний өдрөөс 1944 оны 4 дүгээр сар хүртэл хугацаанд бригад, дивиз, корпусын командлан захирагч цолтой байсан 109 хүнийг генерал гэж үзэх хүмүүс цөөнгүй байдаг. Энэ нь дээрх цолыг генерал цолоор сольсонтой холбоотой юм. Мөн 1937 онд улс төрийн хэлмэгдүүлэлтэд цэргийнхэн ихээр өртөж өндөр албан тушаалтай дээд тушаалын дарга нар /100 орчим гэх тоо бий/ хэлмэгдэлтэд өртөж цаазаар хороогдсон эмгэнэлт түүх бий.

МАХЦ-т 1944 онд шинээр нэвтэрсэн цэргийн дээд цол нь генерал цол бөгөөд эл цолыг эх орныхоо эрхчлөө, тусгаар тогтнолыг



Зүүн талаас: Г.Рэндоо, Д.Дамдинхүү, Ж.Лхагвасүрэн, С.Равдан, Ч.Доржпалам, М.Зайсанов нар. 1944 он



хүчний түүхэнд анх Цэргийн яамны тэргүүн сайд, Бүх цэргийн жанжин Д.Сүхбаатарын 1921 оны 7 дугаар сарын 16-нд гаргасан 2 тоот тушаалд "Цэргийн дарга нараас форма ба ханцуйн тэмдгийг ёсчлон хэрэглэх учрыг заралсугай" гэснээр дарга, цэргүүдийг албан тушаалаар нь зэрэг дэв тогтоож, ялгах тэмдэгтэй болгожээ. Энэ бүхэн нь алба хаагчдын албан тушаалын зэрэг дэв байснаас гадна нөгөө талаасаа цолны илэрхийлэл болж, цэргийн цолны эх үндэс нь болсон юм. Үүнээс хойш цэргийн зэрэг дэв, цол нь түүхэн хөгжлийнхөө явцад олон удаа өөрчлөгдөж ирсэн.

1911, 1914, 1921, 1923, 1931 онд цэргийн зэрэг дэвийг тогтоож, өөрчлөн шинэчилж ирсэн. Энэ дагуу цэргийн алба хаагчдын албаны зэрэг дэвийг ахлах дарга, дунд дарга, бага дарга, цэрэг, хорооны дарга, салааны дарга гэх байдлаар тогтоосон. Энэ нь цэргийн цол бус зөвхөн албан тушаалын зэрэг дэв байв. Харин 1936 оны 2 дугаар сарын 21-нд жинхэнэ ёсоор цэргийн цолыг бий болгохоор Улсын Бага хурлын Тэргүүлэгчид, Ардын сайд нарын зөвлөлийн хамтарсан хурлаас шийдвэрлэсэн байна.

Улсын Бага хурлын Тэргүүлэгчид, Ардын сайд нарын зөвлөлийн 1936 оны 2 сарын 21-ний өдрийн хамтарсан хурлын 14 дүгээр энэхүү тогтоолоор МАХЦ-ийн дарга, улс төрийн ажилчдад олгох цэргийн цолыг бий болгосны зэрэгцээ цол олгох явдал, түүнд тохирох нэмэгдэл цалинг бий болгох, алдар цолд тохирсон хувцас ба тэмдгийн загварыг тус тус баталснаар Монгол Улсад цэргийн цолыг албан ёсоор бий болгож, хэрэглэж эхлэх үндэс тавигдсан ба төрөл мэргэжлийн цэргүүд олноор бий болсон. Мөн 1936, 1940, 1944, 1963, 1990, 1998, 2006, 2011, 2017 онд цэргийн алба хаагчдын дүрэмт хувцасны цолонд өөрчлөлт оруулсан хэд хэдэн эрх зүйн баримт бичиг гарсан юм.


ГЕНЕРАЛ ЦОЛНЫ ТУХАЙД

Анх генерал цолыг Франц Улсад XVI зуунаас хэрэглэж ирсэн бол Орост 1657 онд I Петр хаан армидаа хэрэглэсэн. Монгол Улсад

батлан хамгаалах үйл хэрэгт онц гарамгай гавьяа байгуулсан цэргийн дээд дарга нарт олгох журам гаргаж, БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн 1944 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 52 дугаар тогтоолоор Ю.Цэдэнбал, Ж.Лхагвасүрэн нарт дэслэгч генерал, С.Балдан, Д.Дамдинхүү, С.Равдан, Б.Дорж, Г.Дагдан, Б.Шагдаржав, Г.Рэндоо, М.Зайсанов, Р.Осор нарын 9 хүнд хошууч генерал, бүгд 11 хүнд анх удаа генерал цол олгосноос хойш энэ эрхэм хүндтэй цолонд нийтдээ 186 хүн хүрчээ.

Армийн генерал цолыг 1970 оноос хэрэглэж Ю.Цэдэнбал, Б.Дорж нар хүртсэн бол хурандаа генерал цолыг 1960-аад оноос олгож Б.Цог, Ж.Лхагвасүрэн, С.Батаа, Ж.Авхиа, С.Равдан, Ж.Ёндон, С.Лувсангомбо, Б.Дэжид нар, дэслэгч генерал цолыг 1944 оноос эхлэн олгож Ц.Жанчив, Ц.Самдангэлэг, Б.Жамбалсүрэн, Б.Цэдэн-Иш, Д.Ёндондүйчир, Ч.Түмэндэмбэрэл, Ж.Жамьян, Ч.Пүрэвдорж, Ш.Арвай, Ө.Чойжилсүрэн, Ч.Сангишарав, Ж.Балжинням, Л.Моломжамц, Ш.Жадамбаа, А.Жамсранжав, Ц.Дамдинсүрэн, Ц.Дашзэвэг, Ц.Тогоо, Ц.Бямбажав, Д.Даваа нар, хошууч генерал цолыг 1944 оноос эхлэн олгосон ба нийт 111 хүн хүртсэн. Бригадын генерал цолыг 2006 оноос эхлэн олгосон бөгөөд нийт 41 хүн хүртжээ.

Өнгөрсөн зууны ерээд оноос Монгол Улсын Зэвсэгт хүчинд цэргийн шинэчлэлийн хүрээнд олон арга хэмжээг авч хэрэгжүүлсний нэг нь дэлхий нийтээр даяаршсан, Монгол Улсын Зэвсэгт хүчин олон улсын хэмжээний ажиллагаанд оролцох болсонтой уялдаж, дэлхийн улс орнуудын цэрэг, армид түгээмэл байдаг бригадын генерал цолыг 2006 онд бий болгож, энэхүү цолыг ЗХЖШ-ын Сургалт, зохион байгуулалт эрхэлсэн орлогч Н.Энхбаялаг анхлан хүртсэн байдаг. Монгол Улсын генералууд нь Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Иргэний нисэхийн ерөнхий



Зүүн талаас: С.Равдан, Г.Рэндоо, ар эгнээнд: Д.Дамдинхүү, Р.Осор нар 1944 он

газар зэрэг 8 байгууллагаас төрөн гарчээ. Түүнчлэн генералуудаас улс орондоо манлайлан гарч ирсэн Монгол Улсын баатар 6, Хөдөлмөрийн баатар 3, дайн, байлдаанд оролцсон 34, гавьяат цолтон 11, сансрын нисгэгч 1, эрдмийн зэрэг цолтон 38 төрөн гарсан байдаг.

Хот, аймгуудаар нь авч үзвэл Улаанбаатар хотоос 21, Завхан аймгаас 20, Говь-Алтай аймгаас 18, Архангай аймгаас 17, Төв аймгаас 11, Увс аймгаас 10, Ховд аймгаас 10, Дорнод аймгаас 9, Өвөрхангай аймгаас 9, Сэлэнгэ аймгаас 9, Булган аймгаас 7, Өмнөговь аймгаас 7, Хөвсгөл аймгаас 7, Баянхонгор аймгаас 6, Сүхбаатар аймгаас 6, Дорноговь аймгаас 4, Хэнтий аймгаас 4, Дархан аймгаас 3, Дундговь аймгаас 3, Баян-Өлгий аймгаас 1 генерал цолтон тодорчээ.

Монгол Улсын баатар, маршал Ю.Цэдэнбал 28 насандаа дэслэгч генерал болсноороо манай улсын түүхэн дэх хамгийн залуу генералд тооцогддог төдийгүй армийн Улс төрийн газрын анхны генералын нэг байв. "Залуу жанжин", хурандаа генерал Ж.Лхагвасүрэн 1939 оны Халхын голын байлдаанд 27 настайдаа МАХЦ-ийн орлогч командлагч, 1945 оны Чөлөөлөх дайнд МАХЦ-ийг хариуцсан орлогч байсан төдийгүй цорын ганц ихэр генерал байсан ба түүний нөгөө

ихэр нь хурандаа Ж.Зундуй хэмээх хүн байжээ. Армийн генерал Б.Дорж Баруун хилийн зэвсэгт тулгаралтын үеэр корпус командалсан ба 1956-1959, 1969-1978 онд БХЯ-ны сайдаар ажиллаж байсан нь хамгийн олон жил /12 жил/ БХЯ-ны сайдаар ажилласан генерал юм.

Хурандаа генерал С.Равдан 1938-1939 онд "Улаан од" сонины эрхлэгчээр ажиллахдаа Халхын голын байлдаанд "Эх орны төлөө" фронтын сонины 80 дугаарыг эрхлэн гаргасан, 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон монголын анхны дипломатчдын нэг байсан гэдгээрээ түүхэнд тэмдэглэгдэн үлджээ.

Мөн генералуудын хүүхдүүдээс офицер олноор төрсөн ч генералын хүү генерал болсон тохиолдол ганцхан буюу хурандаа генерал Б.Цогийн хүү хошууч генерал, техникийн шинжлэх ухааны доктор Ц.Геннадий билээ. Хамгийн залуу генерал нь 45 настай, ХХЕГ-ын дарга бөгөөд Хилийн цэргийн командлагчаар ажиллаж байсан бригадын генерал Ж.Бямбасүрэн юм.

Монгол генералуудын хувийн намтар түүхийг сонирхон судалж байхад бүгд байлдагчаас эхлэн эх орныхоо уудам газар нутагт хаа сайгүй ажиллаж, цэргийн бүхий л албан тушаалыг дамжин амаргүй атлаа бахархалтай замыг туулж энэ цолонд хүрсэн

байдаг нь бахархуштай. Тиймдээ "Байлдагчийн халаасанд генералын мөрдөс" хэмээн ярьдаг нь яахын аргагүй үнэн. Аливаа улс орны тусгаар тогтнолын нэгэн баталгаа, эх орноо хамгаалах гол хүчин нь цэрэг, арми байсаар ирсэн. Цэрэг арми байгаа цагт тэднийг удирдах дээд дарга, генералууд байх ёстой бөгөөд энэ ч утгаараа генералуудыг улс орны тусгаар тогтнолын баталгааны нэгэн гол хүчин зүйл гэж үзэж болох юм.

Улс орны бахархал болсон эдгээр хүмүүст ямар нэгэн төрийн хангамж байхгүй ч гэсэн чөлөөнд байгаа болон одоо ажиллаж буй генералууд маань залуу хойч үедээ цэрэг, эх оронч үзлийг төлөвшүүлэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, цэргийн алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт генералуудыг эгнээндээ нэгтгэсэн "Монгол генерал" төрийн бус байгууллагыг 2001 онд байгуулсан. Энэхүү төвийн тэргүүнээр хошууч генерал С.Баасанхүү, дэд тэргүүн буюу гүйцэтгэх захирлаар хошууч генерал З.Болдбаатар нар ажиллаж байна. Уг төв нь жил бүрийн 4 дүгээр сарын 28-ны өдрийг Монгол генералын өдөр болгон тэмдэглэдэг ба өдгөө энх тунх байгаа 90 гаруй генералыг эгнээндээ нэгтгэн амьд түүх болсон ахмад буурлууддаа хүндэтгэл үзүүлж ирсэн билээ.

ГЕНЕРАЛУУДЫН ТҮҮХ ДЭЛХИЙН ХУУДАСНАА

М.МӨНХЗОРИГ

Олон улсын "Britannica" нэвтэрхий тольд "Генерал цолтон нь тухайн улсын армийн дээд офицер бөгөөд бригад эсвэл түүнтэй дүйцэхүйц хэд хэдэн анги, нэгтгэлийг удирддаг. Мөн

XVII-XVIII зууны хооронд Пруссийн эзэнт улс цэргийн жанжууддаа генерал цолыг олноор өгч, төрлийн цэргүүдийг дагнан захирдаг генерал цолтнуудыг анх удаа бий болгожээ. Ингэснээр цэргийн түүхэнд анх удаа артиллерийн, явган цэргийн,



Пруссийн эзэнт улсын фэлд маршал Людвик Фрэдрик фон Макенсен

цэргийн нэгж, бүрэлдэхүүнийг гардан удирдахгүй ч Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинтэй холбоотой цэргийн ажиллагаа, бодлого боловсруулдаг албан тушаалтнийг хэлнэ" гэжээ.

Дундад зууны үед Францын арми нь "Captain general" хэмээх цол хэрэглэдэг байснаас генерал цол үүссэн гэж үздэг. Дундад зууны үед Францын арми хүчирхэгжиж, хороо, дивизүүд олноор байгуулагдах болсонтой холбогдож, хааны шууд томилгоогоор "Lieutenant du roi" нарыг дайны талбарт илгээдэг байжээ. Эзэн хааны итгэмжлэгдсэн цэргийн хэргийн өндөр мэдлэгтэй тэдгээр офицерууд нь байлдааны ажиллагааг шууд гардан зохион байгуулах эрхтэй байв. Удалгүй тэдэнд "Captain general" хэмээх цол олгох болсон байна.

морьт цэргийн командлагч генералууд үүссэн түүхтэй. Удалгүй эдгээр генералыг нэгдсэн удирдлагаар хангадаг албан тушаал Фэлд маршал /Field marshal/ цол бий болж, цөөнгүй улс тус цолыг олгож байсан юм. Одоо ч Хойд Солонгос, Йордан, Малайз, Пакистан зэрэг дэлхийн хэд хэдэн улс Фэлд маршал эсвэл түүнтэй дүйцэх цолыг олгож байна.

Эдүгээ өөрийн гэсэн Зэвсэгт хүчинтэй бүх улсад генерал цол байх бөгөөд тэд өөр өөрсдийн үндэсний онцлог, соёлд тулгуурласан мөрдөсний өнгө, дизайн бүхий цолны ялгааг тэмдэгтэй. Өнөөдрийн байдлаар НАТО-гийн код "OF-9"-ийг дэлхийд хамгийн олон улс генералын цолны системдээ хэрэглэж байна. Харин Хойд Африк, Ойрхи Дорнодын орнууд өөрсдийн араб цолны системийг мөрддөг.



ГЕНЕРАЛУУДЫН ГЕНЕРАЛ БУЮУ ГЕНЕРАЛИССИМУС

ЗХУ-ын цорын ганц генералиссимусын мөрдэс. 1993 оноос энэхүү цэргийн цолыг ОХУ-ын Зэвсэгт хүчний цэргийн цолны жагсаалтаас хассан.

Олон улсад цэргийн хамгийн дээд цол генералыг дөрвөн одтой зэрэглэх тэмдэг, мөрдсөөр тодорхойлдог. Гэхдээ хэд хэдэн улс түүхэндээ түүнээс ч илүү генералиссимус хэмээх цолыг хэрэглэж байсан удаатай. Генералиссимус бол цэргийн дээд хүндэт цол буюу генералуудын генерал гэж утгачилж ойлгож болно. Энэ цолыг Ром, Австри, Оросын эзэнт гүрэн, Франц, Их Британи болон ЗХУ, Швед, Испани, Мексик, Хятад, Япон, Доминикан, БНАСАУ тус тус олгож байсан. Гэхдээ түүхээс харахад уг цолыг цэргийн гавьяа байгуулсан жанжид биш их гүрний эзэн хаад, ерөнхийлөгч, бүс нутгийн эрх мэдэлтэн нарын нэр хүндтэй


улс төрийн зүтгэлтнүүд хүртсэн байдаг.

Хамгийн анхны генералиссимус цолыг 1569 онд Францын хаан Чарльз өөрийн ах Дюкэд олгосон түүхтэй. Нийтдээ энэ цолыг 84 хүн хүртсэн. Дээрх хүмүүсийн дотроос ганцхан Оросын нэрт цэргийн жанжин А.В.Суворов генералиссимус цолыг өөрийн хатан зориг, цэргийн мэргэжлийн гайхалтай авьяас билиг, ялалтуудаараа хүртжээ. Тэрбээр олон ч тулалдаанд оролцож байснаас Римникийн тулаан, Швейцарь дахь Альпийн аян дайныг удирдснаараа 1799 онд тус цолыг хүртжээ. Харин бусад цэргийн удирдагчид дайн, байлдааныг гардан удирдах гэхээс илүү улс төрийн

нөлөөгөөр авсан байдаг.

Генералиссимусууд дундаас түүхэнд хамгийн их тод мөр үлдээсэн хүн нь И.Сталин юм. Тэрээр Дэлхийн II дайны дараа 1945 оны 6 дугаар сарын 26-ны ЗХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн зарлигаар уг цолыг хүртсэн. Яг ийм жишээгээр Хойд Солонгосын Ким Ир Сен, Ким Чен Ир, Хятадын Юань Шикай, Сүн Ятсен, Чан Кайши, Японы гурван эзэн хаан, Испанийн удирдагч Франко гэх зэрэг олон хүнийг нэрлэж болно. Оросын анхны генералиссимус бол Шейн Алексей Семенович 34-хөн насандаа 1696 онд уг цолыг хүртэж байв.

ТҮҮХЭНД ҮЛДСЭН ХАМГИЙН ЗАЛУУ ГЕНЕРАЛ



Галуша Пеннипэкр 1844-1916 онд Америкт амьдарч байсан бригадын генерал цолтой нэгэн байв. Тэрээр хүүхэд байхаасаа өвөө, аав, ах нарыгаа дагаж Америкийн иргэний дайнд оролцож явжээ. Ингээд 16 настайдаа Пенсилвани мужийн Вэст Честер явган цэргэ бэлтгэх ангид элсэн орж, жилийн дараа 1861 оны 8 дугаар сард 97 дугаар явган цэргийн ангид салааны захирагч, ахмад цолтой алба хашиж эхлэв. Удалгүй түүний удирдсан салаа Чарлестоны тулалдаанд

онцгой гавьяа байгуулсан тул хоёрхон сарын дараа хошууч цолоор шагнуулав.

1864 онд 97 дугаар явган цэргийн анги Виржиниа муж руу нүүж, тэрээр хошууч генерал Бенжамин Батлерийн удирдлага дор хэд хэдэн тулалдаанд цэргүүдээ гарамгай удирджээ. Ялангуяа, дайсны бүслэлтээс уран арга хэрэглэж мултарт чадсан нь хошууч генерал Бенжамин Батлерийн анхаарлыг ихэд татав. Тиймээс 1964 оны 8 дугаар сард түүнд хурандаа цол олгож, 5 дугаар дивизийн 2 дугаар бригадын захирагчаар томилжээ. Тэрээр бригадтайгаа Өмнөд Виржиниагийн тулалдаанд оролцож явахдаа шархадсан юм.

Гэвч шархаа үл тоон Форт Фишерийн тулалдаанд цэргүүдээ гарамгай удирдан ялалт байгуулсан ч биедээ хэд хэдэн хүнд шарх нэмж авчээ. Түүний эр зориг, гайхалтай чадварыг цэргүүд ам дамжин ярилцах болсноор тун удалгүй дээд удирдлагад энэ тухай яриа хүрсэн аж. Өмнөд бүсийн командлагч генерал Терри Алфред өөрийн биеэр хүрэлцэн ирж, түүнд "Эр зоригийн одон" гардуулж, шархаа эдгээд эргээд ирвэл дивиз командлуулах болно гэж түүнд амалсан байна. Ингээд 10 сар эмнэлэгт хэвтэн эмчлүүлсний дараа 1865 оны 1 дүгээр сард түүнд бригадын генерал цол хүртээсэн юм. Тэр үед Галуша Пеннипэкр ердөө 20-хон настай байжээ.

Тэрээр Иргэний дайны дараа 17, 64 дүгээр армийн командлагчаар тэтгэвэрт гаран гартлаа албаа үргэлжлүүлэн хаасан юм. Дайн дууссанаас хойш 52 жилийн дараа өмнө нь тулалдааны талбарт авч байсан шархнаасаа болж, 1916 онд амьсгал хураасан аж. Түүний хөшөө эдүгээ Виржиниа мужийн Логан талбайд байдаг. Эр зориг, цэргийн мэргэжлийн гайхалтай ур чадварыг нь одоо ч хүмүүс ярьсан хэвээр.

ДАЙСНАА ХЭЗЭЭ Ч БИТГИЙ ДУТУУ ҮНЭЛЖ БАЙ


Дэлхийн I дайны үед Германы армийг удирдаж байсан генерал Эрих Людендорфыг тулалдаанд бүрдээ ялалт байгуулдаг цэргийн шилдэг удирдагч гэж хэлж болохоор байв. Гэвч Германы армийг Холбоотнуудад ялагдах гол шалтгааныг үүсгэсэн гэж судлаачид үздэг. Уг дайны эхний саруудад Тананбергийн тулалдаанд Людендорфын удирдсан арми Оросын эсрэг тулалдаж ялалт байгуулав. Үүний дараа тэрээр Франц руу дайрах "Шлиффений төлөвлөгөө"-г шинэчлэн боловсруулж, Германы Жанжин штабын дарга Хельмут фон Молткед танилцуулав. Төлөвлөгөө ёсоор Германы арми дайны баруун фронтод үндсэн хоёр фронто болж хуваагдан байлдахаар шийджээ. Ингээд Францын эсрэг хийсэн Марнегийн тулалдаанд Германчууд шууд утгаараа ялагдаагүй ч зорьсондоо хүрч чадсангүй. Учир нь

Людендорф дайснаа дутуу үнэлсэн байлаа. Үүнээс болж Германы баруун фронт Франц болон Холбоотнуудын дунд гацав. Энэ үед Людендорф байлдааны ажиллагаанд хараахан бэлэн болоогүй байсан шумбагчуудыг Холбоотнуудын байлдааны усан онгоцуудын эсрэг тулалдаанд оруулах тушаалыг өгсөн нь маш том алдаа болжээ. Тухайн үедээ маш их төсөв зарцуулж хийгдэж байсан шумбагчууд дайсны байлдааны хөлөг онгоцуудын эсрэг юу ч хийж чадаагүй юм. Олон зуун герман цэрэг тус тулалдаанд амь эрсэдсэн. Энэ бол Германчуудын амссан гутамшигт ялагдлуудын нэг байлаа. Үндсэндээ Герман Дэлхийн I дайнд ялагдаж, Адольф Гитлерийн ноёрхол бий болох олон нөхцөлийн нэг нь яах аргагүй Людендорф генералын буруутай шийдвэрүүд суурийг нь тавьсан гэж түүхчид үздэг билээ.



ЦАХИМ ШУУДАНД

ГЭР БҮЛИЙН ХАМТ ЗЭВСЭГТ ХҮЧИНД АЖИЛЛАЖ БАЙГААДАА МАШ ИХ БАЯРЛАЖ ЯВДАГ



сургалтын төвийг тогооч мэргэжлээр, 2017 онд Радиотелеграфчны анхан шатны дамжааг, 2018 онд Зэвсэгт хүчний 325 дугаар ангид Цэргийн мэргэжлийн анхан шатны сургалтад тус тус хамрагдаж төгссөн. Зэвсэгт хүчинд ажиллаад 3 жил ажиллаж байна.

Гэр бүлээ танилцуулахгүй юу?

-Нөхөр хүүхдийн хамт амьдардаг. Нөхөр Я.Балжинням Батлан хамгаалахын их сургуулийн Ахлагчийн сургуулийг 2016 онд радио холбоочин мэргэжлээр төгссөн. Одоо тус ангийн 274 дүгээр тусгай ротод планшетчинаар ажилладаг. Хүү Б.Түвшинбаяр хоёрдугаар ангид сурдаг. Гэр бүлийн хамт Зэвсэгт хүчинд ажиллаж байгаадаа маш их баярлаж явдаг даа.

Та ажил мэргэжлийнхээ талаар юу гэж боддог вэ?

-Миний бодлоор мэргэжил бүхэн сайхан. Тэр тусмаа холбоочин байх илүү сайхан. Хариуцсан ажлаа алдаа мадаггүй гүйцэтгэх нь миний хамгийн том зорилго. Залуу хүний хувьд алба нэр төртэй гүйцэтгэж хамт олонтойгоо мөр зэрэгцэн ажиллаж байна.

Таны хобби юу вэ?

-Би спортоор хичээллэх сонирхолтой. Хүүхэд байхаасаа л тэмцээн уралдаанд их оролцдог байсан. Цэргийн албанд ороод аймаг, орон нутаг болон Агаарын цэргийн командлалын мөн Зэвсэгт хүчний аварга шалгаруулах 2020 оны спортын тэмцээнүүдэд амжилттай оролцож, алт мөнгөн медалиуд хүртсэн.

Зэвсэгт хүчинд алба хааж байгаа залуу үеийнхэндээ хэлэх үг юу вэ?



Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Танд энэ өдрийн мэндийг хүргэе. Та өөрийгөө танилцуулах уу?

Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Намайг Д.Пүрэврагчаа гэдэг. Завхан аймгийн Сонгино суманд төрсөн. 2012-2016 онд Хөдөө аж ахуйн их сургуулийг ургамал судлалын мэргэжлээр төгссөн. Мөн 2016 онд "Чухал амжилт"

-Залуу офицер ахлагч нарт хэлэхэд бид түүхэн цаг үед ажиллаж амьдарч байгаа нэгэн үеийн Зэвсэгт хүчний төлөөлөл юм. Тийм учраас Зэвсэгт хүчнийхээ нэр хүндийг өндөрт өргөж, эзэмшсэн мэргэжилдээ эзэн нь байгаарай гэж хэлбэ. Ярилцсанд баярлалаа.

Ахмад Н.МӨНХБААТАР

ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРАГДАЖ ЭХЭЛЛЭЭ

Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Зэвсэгт хүчний 340, 331 дүгээр анги болон тусгай салбарын алба хаагчид, тэдний ар гэрийнхэн энэ сарын сарын 26-27-нд дархлаажуулалтын эхний тунд хамрагдав.

Алба хаагчдынхаа эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэж, тэдний эрүүл мэндийн үйлсэд хоёргүй сэтгэлээр хандаж байгаа ЗХЖШ, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Цэргийн төв эмнэлгийн алба хаагчдаа талархаж байгаа аж. Вакцинжуулалтын хоёрдугаар тунд ирэх 6 дугаар сард хамрагдана.

Дэслэгч Ц.ДОЛГОРСҮРЭН



НИЙСЛЭЛД 45-ААС ДЭЭШ НАСНЫХНЫГ "VERO CELL"

ВАКЦИНЫ ЭХНИЙ ТУНД ХАМРУУЛЖ ЭХЭЛЛЭЭ

Өчигдөр нийслэлийн есөн дүүрэг дэх дархлаажуулалтын цэгүүдэд 2100 эрүүл мэндийн ажилтан ажиллаж, 50750 иргэнийг "AstraZeneca", "Vero Cell" вакцины давтан тунд болон 45-аас дээш насны иргэдийг "Vero Cell" вакцины эхний тунд хамруулжээ.

Тодруулбал, Багануур дүүрэгт 400, Багахангай дүүрэгт 80, Баянзүрх дүүрэгт 10000, Баянгол дүүрэгт 11000, Сонгинохайрхан дүүрэгт 9550, Сүхбаатар дүүрэгт 5000, Налайх дүүрэгт 600, Чингэлтэй дүүрэгт 5100, Хан-Уул дүүрэгт 9050 хүнийг дархлаажууллаа. Дархлаажуулалтын ажлыг энэ сарын 23-наас эрчимжүүлсэн бөгөөд эхний ээлжид вакцины хоёр дахь тунд хамрагдах иргэд болон 50-аас дээш насныхныг хамруулж байгаа юм.



ӨМЧ ХӨРӨНГИЙН ХАДГАЛАЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛНА



Агаарын цэргийн командлал

Тус командлалын Санхүүгийн хэлтсээс Төсвийн тухай хууль, түүний хэрэгжилт, төсвийн хэмнэлтийг зохион байгуулах, төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах, анхан шатны бүртгэлд хөтөлгөх баримт бичиг, түүнд тавигдах шаардлага, хагас жил, жилийн эцсийн эд хөрөнгийн тооллыг чанартай хийх, үр дүнг тооцож ажиллах, цалин хөлсний бүртгэл, холбогдох тушаал шийдвэрийн хэрэгжилт, Шилэн дансны тухай хууль, шилэн дансны мэдээллийг цахим системд хуулийн хугацаанд нь үнэн зөв байршуулахад анхаарах асуудлууд зэрэг сэдвүүдээр Агаарын цэргийн анги, салбаруудын захирагч, санхүүгийн дарга, нягтлан бодогч, ар талын албадын дарга нарт энэ сарын 26-нд цахим сургалтыг явууллаа.

Сургалтыг төсвийн болон нягтлан бодох бүртгэл, худалдан авалтын талаарх хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, төсвийг үр ашигтай зарцуулах, өмч хөрөнгийн хадгалалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах зорилгоор зохион байгуулсан юм. Энэ үеэр төсвийг үр ашигтай зарцуулах, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, санхүүгийн зөрчил, дутагдлаас урьдчилан сэргийлэх, ЗХЖШ-ын дарга, Агаарын цэргийн командлагчийн тушаал шийдвэр, албан даалгаврын хэрэгжилт, анги байгууллагад тулгамдаж буй асуудлаар харилцан санал солилцов. Сургалтын төгсгөлд Агаарын цэргийн командлалын санхүүгийн хэлтсийн дарга, дэд хурандаа П.Дэлгэр холбогдох албан тушаалтнуудыг дээрх хууль тогтоомж, албан даалгавруудын хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүрэг болголоо.

КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СЭРЭМЖЛҮҮЛЭГ

КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СЭРЭМЖЛҮҮЛЭГ

1.Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын зүгээс авах арга хэмжээ:
-Нийт бие бүрэлдэхүүнд шинэ коронавирүсын халдварын талаар баталгаатай эх сурвалжаас авсан үнэн, бодит мэдээллээр хангаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлтөд тодотгол хийж, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг эрчимжүүлэх;

-Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яам болон мэргэжлийн байгууллагуудаас гаргасан шийдвэрүүд, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/135 тушаалыг хэрэгжүүлэх;
-Нэгтгэл, анги, байгууллагуудын эмнэлгүүдийн тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангах;

"Цэргийн албыг зохион байгуулах заавар", "Цэргийн гал тогоо, хоолны газрын эрүүл ахуй, ариун цэврийн дүрэм", "Цэргийн ангийн эмч, эмнэлгийн мэргэжилтний эрүүл ахуй, халдвар судлалын ажлын заавар"-ыг чанд мөрдөж, ангийн эмнэлгийн зүгээс тавих дотоодын хяналтыг нэмэгдүүлэх;
-Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгуулагад олон нийтийг хамарсан арга хэмжээг цуцлах, бие бүрэлдэхүүнийг онцгой шаардлагагүй тохиолдолд гадуур ажлаар явахыг хориглох;

-Нэгтгэл, анги, салбар, байгууллагын байрлал, шалган нэвтрүүлэх цэгүүд, барилга байгууламжийн орох-гаргах гарц, ариун цэврийн өрөө, коридор, хичээлийн болон соёл амралтын танхим, номын сан зэрэг хүн олноор цугларах боломжтой газруудад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлийг байрлуулах;

-Улаанбаатар хотоос гадагш чиглэсэн хөдөлгөөнийг бүрэн хориглох;
-Нийт бие бүрэлдэхүүний халууныг өдөрт 2-оос доошгүй удаа үзэж, биеийн байдал, эрүүл мэндийг хянаж, бүртгэл хөтлөх;
-Сэжигтэй тохиолдол илэрсэн тохиолдолд яаралтай тусгаарлаж, ХӨСҮТ болон бүсийн халдварт өвчин хариуцсан мэргэжлийн байгууллага, ЗХХШҮГ, АТГ-ын ЭМХХ-т яаралтай мэдэгдэж, хариу арга хэмжээ авах;

-Байнгын байрлал, өрөө тасалгаа, гадна болон дотор ариун цэврийн өрөө, бие засах газар, хог хаях цэгт ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийж;

-Хугацаат цэргийн алба хаагчдын биеийн дархлааг сайжруулах зорилгоор шим тэжээл сайтай хоолоор

хангаж, сармис, аарц, чацаргана зэргийг тогтмол хэрэглүүлэх;

-Хугацаат цэргийн алба хаагчдын чөлөө, эргэлт, уулзалтыг бүрэн зогсоох, нэгтгэл, анги, байгууллагын байрлалд гаднаас нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах, гадна хүн нэвтэрсэн тохиолдолд ямар хүн, хаанаас ирсэн, гэрийн хаяг зэргийг авч бүртгэл хөтлөх, нэгтгэл, анги, байгууллагын байрлалд нэвтэрч буй хүмүүст амны хаалт хэрэглэхийг шаардах, амны хаалтгүй хүн нэвтрүүлэхгүй байх;

2. ХУВЬ ХҮНИЙ ЗҮГЭЭС АВАХ АРГА ХЭМЖЭЭ:

-Нэгтгэл, анги, байгууллагын байрлал, албаны өрөөндөө амны хаалт тогтмол хэрэглэх, 2-3 цаг тутам сольж хэрэглэх;

-Хүнтэй гар барихаас зайлсхийх, амьсгалын замын ямар нэгэн өвчтэй хүнтэй хамт байхаас зайлсхийх;

-Бусдын албан тасалгаа, өрөөгөөр сэлгүүцэхгүй байх;

-Нийтийн эзэмшлийн зам талбайд нус, цэрээ ил задгай хаяхгүй байх;

-Ханиаж найтаах үед ам, хамрыг амны алчуур, сальфеткаар таглах;

-Гараа сайтар савандаж угаах, гар ариутгах уусмалыг хэрэглэж хэвшиж;

-Өвчлөл гарсан орон, бүс нутагт зорчихгүй байх;

-Олон хүн цугласан газар, зах, үзвэр, үйлчилгээний газар, тоглоомын газар, интернэт кафе, бар, ресторанаар үйлчлүүлэхгүй байх;

-Онц шаардлагагүй бол эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлэхгүй байх;

-Амин дэмээр баялаг хоол хүнс хэрэглэх, мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг гүйцэд болгож хэрэглэх;

-Архи согтууруулах ундаа нь дархлааг бууруулдаг тул хэрэглэхгүй байх;

-Ажил амралтаа зохицуулах, дасгал хөдөлгөөн хийх;

-Эрүүл мэндийн яам болон эмнэлгийн байгууллагаас өгч байгаа зөвлөмжийг тогтмол хэрэглүүлэх;

-Халуурах, ханиалгах, цээжээр өвдөх шинж тэмдэг илэрсэн тохиолдолд өөрийгөө тусгаарлан, бусадтай харьцахаас зайлсхийх, холбогдох эрүүл мэндийн байгууллагад утсаар мэдэгдэх, 119 дугаараас зөвлөгөө авах.

ЗХЖШ-ын зохион байгуулалтын нэгжүүд, Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, байгууллагууд энэхүү сэрэмжлүүлийг үндэслэн, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг зөвлөж байна.

ЗХЖШ-ЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЭЛТЭС